



**НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 02 сарын 18 өдөр

Дугаар А/20

Улаанбаатар хот

Г Менингококк халдвараас сэргийлэх Г
арга хэмжээг эрчимжүүлэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Засгийн газрын 2017 оны “Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр батлах тухай” 11 дүгээр тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2008 оны “Менингококкт халдвартай тэмцэх, сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх тухай” А/37 тоот, НЭМГ-ын даргын А/13 тоот тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Менингококкт халдвараас урьдчилан сэргийлэх болон өвчлөл гарсан үед голомтын хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэх арга хэмжээнд ЭМТ-ийн даргын 2019 оны А/17 тоот тушаалаар баталагдсан тандалтын багийг зохион байгуулж удирдлага арга зүйгээр ханган ажиллахыг НЭМТҮЭО дарга /Б.Лувсанням/-д даалгасугай.
2. Эмчилгээ эрхэлсэн орлогч даргад даалгах нь:
 - 2.1.Өвчлөл гарсан тохиолдолд голомтод мэргэжлийн багийг 24 цагийн дотор яаралтай томилон, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах
 - 2.2.Менингококкт халдварын бүртгэгдсэн тохиолдол бүрийг чанарын хурлаар хэлэлцүүлэн, цаашид авах арга хэмжээг төлөвлөх
 - 2.3.Тасаг нэгжүүдийн дарга эрхлэгч нарын болон голомтод ажиллах багийн ахлагч, мэргэжилтнүүдийн холбогдох утсыг нээлттэй байлгаж, мэдээллийг цаг алдалгүй солилцож ажиллах
 - 2.4.Менингококкт халдварын оношилгоо, эмчилгээг хийх, голомтод авах хариу арга хэмжээнд шаардлагатай урвалж оношлуур, яаралтай тусламжийн хэрэглэх эм, тариа болон сургууль цэцэрлэгээс илэрсэн хамар залгиурын үрэвсэлтэй хүүхдүүдэд шинжилгээг хийх лабораторийн бэлэн байдлыг хангах
 - 2.5.Хүлээн авах тасгаар үйлчлүүлж байгаа иргэдийг эрэмбэлэн ангилж, сэжигтэй тохиолдлуудыг тусгаарлаж, эмнэлгийн тусламж үйлчилгээг зохих заавар, журам, стандартын дагуу үзүүлэх
3. Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нарт даалгах нь:

60170 70 013

- 3.1 Өндөр халуурсан, арьсаар тууралт гарсан , бөөлжсөн, таталт өгсөн дуудлагад онцгой анхаарч, эрэмбэлэн ангилалтыг зөв хийж, тусламж, үйлчилгээг хугацаа алдалгүй үзүүлэх, эмнэлэг хооронд түргэний машинаар эмчийн хяналтан дор тээвэрлэх
- 3.2 Өрхийн эрүүл мэндийн төвөөр үйлчлүүлж байгаа иргэдийг эрэмбэлэн ангилж, сэжигтэй тохиолдлуудыг тусгаарлаж, эмнэлгийн тусламж үйлчилгээг зохих заавар, журам, стандартын дагуу үзүүлэх
- 3.3. Хорооны нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус эмчгүй сургууль цэцэрлэгүүдийн хүүхдүүдийн дунд хамар залгиурын үзлэгийг хийж эрүүлжүүлэх арга хэмжээг авч ажиллах
4. Нэмэлт дархлаажуулалт хийхэд шаардлагатай вакцин ,зүү, тариур, аюулгүй хайрцагны бэлэн байдлыг хангахыг вакцинатор /Д.Мөнхцэцэг/-т даалгасугай.
5. Дүүргийн сургууль, цэцэрлэгийн нэгдсэн тоог гаргаж, үзлэгийн мэдээг нэгтгэж НЭМГ-т хүргүүлэхийг Үйл ажиллагааны тайланг сар бүрийн сүүлийн 7 хоногийн Пүрэв гарагт багтаан НЭМГ-т хүргүүлж байхыг тархвар судлаач /Н.Ганчимэг/-т даалгасугай.
6. Менингококкт халдварын эрт сэрэмжлүүлэг, хариу арга хэмжээ, ялган оношлогоо, эмчилгээний талаар эмч, эмнэлгийн мэргэжилтэн сургууль, цэцэрлэгийн эмч нарт сургалт тогтмол зохион байгуулахыг Халдвартын эмч /П.Төгсжаргал/-д үүрэг болгосугай.
7. Менингококкт өвчний талаар мэдээлэл сэрэмжлүүлэг, сурталчилгааг олон нийтэд өргөнөөр сурталчилахыг сургалтын арга зүйч /Ч.Гүнчинхорлоо/-д үүрэг болгосугай.
8. Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын албаны дарга /Н.Оюунмэд/-д даалгасугай.

ДАРГА



Э.БОДЬЦЭЦЭГ